



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/154

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ний өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын зөвлөлийн 2022 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 2 дугаар хурлын шийдвэрийг үндэслэн “2022 оныг Хоршооны хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан 19 сумын үзүүлэх сургалт туршлага судлах арга хэмжээ зохион байгуулсан зардалд 1,520,000 (нэг сая таван зуун хорин мянган) төгрөг, Өвөрхангай аймгийн Мал эмнэлгийн газар, 19 сумын Мал эмнэлгийн үржлийн тасгийн нэгж, Мал эмнэлгийн тасаг хамтарсан үзүүлэх сургалт зөвлөгөөн зохион байгуулсан арга хэмжээний зардалд 1,000,000 (нэг сая) төгрөг, ойн сангийн 70 хувьд тархсан хортон шавьж устгах зардалд 2,373,550 (хоёр сая гурван зуун далан гурван мянга таван зуун тавин) төгрөг, Улсын аварга шалгаруулах хавчаахай харвааны тэмцээн зохион байгуулах зардалд Монгол улсын харшгүй мэргэн цол хүртсэн С.Пүрвээ, Таравжамба нарт хүндэтгэл үзүүлэхэд 890,000 (найман зуун ерэн мянга) төгрөг, Монгол улсын гавьяат эдийн засагч цол хүртсэн Р.Аюушцэрэнд хүндэтгэл үзүүлэх зардалд 1,300,000 (нэг сая гурван зуун мянган) төгрөг, Улсын аварга малчдад хүндэтгэл үзүүлэх зардалд 145,000 (нэг зуун дөчин таван мянган) төгрөг, малын гоц халдварт шүлхий өвчин гарсан үед ажилласан албан хаагчдын хүнсний зардалд 2,284,100 (хоёр сая хоёр зуун наян дөрвөн мянга нэг зуун) төгрөг, утасны нэгжийн төлбөрт 118,000 (нэг зуун арван найман мянга) төгрөг, цанын улсын аварга шалгаруулах тэмцээнд урилгаар ирсэн зочидод хүндэтгэл үзүүлэх зардалд 1,430,000 (нэг сая дөрвөн зуун гучин мянган) төгрөг, шатахууны зардалд 2,167,200 (хоёр сая нэг зуун жаран долоон мянга хоёр зуун) төгрөг, хоолны зардалд 3,135,800 (гурван сая нэг зуун гучин таван мянга найман зуун) төгрөг, Ахмадын баярын арга хэмжээнд зориулж 117,200 (нэг зуун арван долоон мянга хоёр зуун) төгрөг, Цэргийн штабын ажлын хэсгийн гүшүүдын хоолны зардалд 125,600 (нэг зуун хорин таван мянга зургаан зуун) төгрөг, Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн шинэ жилийн нээлтийн үеэр зорилтот өрхийн хүүхдүүдэд хичээлийн хэрэгслийн зардалд 250,000 (хоёр зуун тавин мянга) төгрөг, хөдөө аж ахуйн тооллогын хяналтын ажлын хэсгийн гишүүдийн хоолны зардалд 140,000 (нэг зуун дөчин мянган) төгрөг, нийт 16,996,450 (арван зургаан сая есөн зуун ерэн зургаан мянга дөрвөн зуун тавин) төгрөг зарцуулсугай.

622207319

2. Зардалд шаардагдах 16,996,450 (арван зургаан сая есөн зуун ерэн зургаан мянга дөрвөн зуун тавин) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН